



УЛААНБААТАР ХОТЫН  
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН  
ТУШААЛ

2016 оны 08 сарын 09 өдөр

Дугаар А/100

Улаанбаатар хот


Ажлын хэсэг байгуулах тухай

Хот тосгоны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.4 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дугаар захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах мэдээлэх журам”-ын 2 дугаар хэсгийн 2.4.1 дэх заалт, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 1 дүгээр хэсгийн 1.3, 2 дугаар хэсгийн 2.9 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Даншиг наадам-Хүрээ цам арга хэмжээний үеэр олгогдсон хуушуурын зөвшөөрлийн талаар тус албанд иргэдээс ирүүлсэн гомдлын дагуу “Монгол Наадам” цогцолбор ОНӨТҮГ-ын үйл ажиллагаанд шалгалт хийж дүгнэлт гаргах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Э.Энхцэцэг	Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга
Гишүүд:	Ц.Рэгзэдмаа	Үйл ажиллагааны мониторингийн хэлтсийн дарга
	Д.Булган	Ахлах нягтлан бодогч
	Э.Уянга	Захиргаа, санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга:	Б.Мөнхбаяр	Үйл ажиллагааны мониторингийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

2. Шалгалтыг зохих хууль, журамд нийцүүлэн зохион байгуулж дүгнэлтийг 2016 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн дотор Улаанбаатар хотын Ерөнхий менежерт танилцуулахыг Ажлын хэсэг /Э.Энхцэцэг/-т даалгасугай.

ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР БӨГӨӨД  
ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙН ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ  Т.ГАНТӨМӨР



УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН ТУШААЛ

D:\backup\_old\_pc\Work documents\doc 2016\tushaal 2016.docx

1110300441